



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2018. 06. 08 № 28

Асуулга тавих тухай

Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх танд дараах асуулгыг тавьж, түүний хариуг хуулийн дагуу УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр хандаж байна.

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг УИХ-ын 2009.07.16-ны өдөр баталсан билээ. Энэ хууль хэрэгжсэн цагаас эхлэн зун зуншлага сайжирч, ширгэж байсан олон гол горхи сэргэж эхэлсэн тухай...2012. 05. 17-ны өдөр баталсан “Усны тухай” хуулийн 7.7.3-т заасны дагуу жил тутам явуулдаг усны тооллогын дүн, судалгааны тоо баримт бий. Гэтэл дээрх хуулийн зарим заалтыг хязгаарлан дагаж мөрдөх журмын тухай хуулинд өөрчлөлт оруулсны уршгаар тогтож эхлээд байсан байгалийн тэнцвэр эргээд алдагдах болсон нь хэн бүхний нүдний өмнө илт байна. Үүний тодорхой жишээ нь гол горхи олноороо ширгэх, жил дараалан хур бороо орохгүй ган, зуд нүүрлэх, үлийн цагаан оготно ихсэж, өвс ургамал, бэлчээрийг ихээр сүйтгэх, цөлжилтийг тэлэх үндэс болж байгаагаас шалтгаалан мал аж ахуй эрхлэх боломж нөхцөл хүндэрч байна.

Иймд дараах тулгамдсан асуудлуудаар ямар бодлого, төлөвлөгөөтэй ажиллаж байгаа тухайгаа тодорхой судалгаа, тооцоо бүхий дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.

1.“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн зарим зохицуулалтыг хязгаарласан дагаж мөрдөх журмын тухай хуулийг өөрчлөх шаардлагатай эсэх.

2.Цөлжилтийг хязгаарлах, бэлчээрийг талхлагдлаас хамгаалах, туурайн зудаас сэргийлэх, бэлчээр, отор нүүдлийг болон хадлан, тэжээл бэлтгэх ажлыг оновчтой зохион байгуулах талаар ямар бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлж байна вэ.

3.Жил дараалан ган тохиолдож байгаа, бэлчээрийн гарц муу байгаа, үлийн цагаан оготно ихээр тархсан энэ жилийн хувьд өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлыг хэрхэн зохион байгуулах гэж байна вэ.

4.Их хэмжээгээр тархсан, хомсхон бэлчээрийг сүйтгэж байгаа үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг хэрхэн зохион байгуулах вэ. (Механик устгал хийх тухайлбал үүр өрхийг

0000000055

ухах) ус цутгах, утах, хордуулсан будаа цацах зэрэг аргыг хэрэглэх нь усны нөөц хомсхон байгаа, нэгэнт ногоо ургасан учир хортой хүнсийг идэхгүй байх нөхцөл бүрдсэн энэ үед хэрэглэх арга механизмаа хэрхэн харж байна вэ?

Улс, орон нутгийг хамарсан, хойшлуулшгүй шуурхай арга хэмжээ авах бодол, төлөвлөгөө байна уу.

5.Өвс тэжээл бэлтгэх, отор нүүдэл хийх, хашаа саравч, худаг усаа хамгаалах, өвс, тэжээлийн аюулгүй, нөөц бүрдүүлэх зэргээр өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажил бодлого, төлөвлөгөөгөө хэрхэн тодорхойлж байна вэ. Өнгөрсөн өвлийг хохирол багатай давах талаар төр, засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдсэн хөрөнгө зардал, татварын хөнгөлөлт дэмжлэгийн үр дүнд дүгнэлт хийх УИХ-д тайлагнах саналыг хүргүүлж байна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд бичгээр ирүүлж, УИХ-ын 2018 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.БАТ-ЭРДЭНЭ

Ч.УЛААН